

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

**Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх тухай**

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16 дахь заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2 дахь заалт, “Худалдаа, хөгжлийн банкны дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь хэсэг, 7.4.13, 7.4.14 дэх заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас **ТОГТООХ нь:**

1. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн энгийн хувьцааны нэг бүрийн нэрлэсэн үнийг 6,736.10 (зургаан мянга долоон зуун гучин зургаан төгрөг, арван мөнгө) төгрөг, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 340,852,904,364.70 (гурван зуун дөчин тэрбум найман зуун тавин хоёр сая есөн зуун дөрвөн мянга гурван зуун жаран дөрвөн төгрөг, далан мөнгө) төгрөгөөр тус тус тогтоосугай.

2. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарсан тогтоолыг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж, нээлттэй ил тод мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргэж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Н.Нямсүрэн)-д үүрэг болгосугай

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА

  
РАНДОЛФ КОППА

ХУРЛЫН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

  
Н.НЯМСҮРЭН



2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 13


Улаанбаатар хот

**Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрэм батлах тухай**

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.1 дэх заалт, “Худалдаа, хөгжлийн банкны дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.4.1 дэх заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ТОГТООХ нь:

1. “Худалдаа, хөгжлийн банк хувьцаат компанийн дүрэм”-ийг энэхүү тогтоолын Хавсралт 1-ийн дагуу баталсугай.
2. “Худалдаа, хөгжлийн банк хувьцаат компанийн дүрэм”-ийг холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудад зохих журмын дагуу бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА

  
РАНДОЛФ КОППА

ХУРЛЫН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Н.НЯМСҮРЭН

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

### Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.8 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг болон “Худалдаа, хөгжлийн банкны дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас **ТОГТООХ нь:**

1. Дараах нэр дэвшигчдийг Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

- 1.1. Жалбаагийн Болормаа;
- 1.2. Жамсрандоржийн Дэлгэрсайхан;
- 1.3. Загдхүүгийн Нарантуяа.

2. Дараах нэр дэвшигчдийг Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

- 2.1. Рандолф Коппа;
- 2.2. Должингийн Эрдэнэбилэг;
- 2.3. Дагмидын Янжмаа;
- 2.4. Дамбийжавын Хүрэлбаатар;
- 2.5. Авгааны Энхмэнд;
- 2.6. Дэмчигжавын Отгонбилэг.

3. Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс болон бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын дүрэм, журам, заавар, Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бусад шаардлагатай дүрэм, журам, зааврыг чанд баримтлан ёс зүйтэй, хариуцлагатай ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



  
РАНДОЛФ КОППА

  
Н.НЯМСҮРЭН